*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН БЭЛЧЭЭР ГАЗАР ТАРИАЛАНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ӨЛЗИЙБАТ ОВОГТОЙ ЗОЛБАЯРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. “БЭЛЧЭЭР ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, СТАНДАРТ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, НОРМ НОРМАТИВЫГ СУРТАЛЧЛАХ, ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Таримал тус бүрээр тариалах талбай, хураан авах ургацын хэмжээг тооцож, хэрэгжилтийг зохион байгуулах байгуулах (Тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөөг хавсаргав. Хамтран ажиллах 2024 оны гэрээний 1 дүгээр хавсралт) | Тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөөг баг, аж ахуйн нэгж, иргэнээр, таримлын төрөл тус бүрээр задлан эзэнжүүлж хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулсан байна. | Төмс 80 га-с 776 тн, хүнсний ногоо 52,9 га-с 481,9 тн, ногоон тэжээл 31,4 га-с 94,2 тн-ыг хураан авсан. | Төмс – 80 га, хүнсний ногоо – 40 га, жимс, жимсгэнэ – 3 га, малын тэжээл – 12 га талбайд тус тус тариалалт хийсэн байна | Засгийн газрын 2024 оны 118 дугаар тогтоолын дагуу 80 хувийн хөнгөлттэй үнээр төмс-1 тн, саримс 500 кг, төл сонгино- 800 кг, бусад нарийн ногооны 75 кг үрийг хөнгөлттэй нөхцөлөөр олгож, 20 аж ахуй нэгж, 202 иргэн тариалалт хийснээс төмс 80 га-с 736 тн, хүнсний ногоо 48,4 га-с 431,1 тн, ногоон тэжээл 20 га талбайгаас 56 тн-ыг хураан авч, дотоодын хэрэгцээг төмс-68,1 хувь, хүнсний ногоо –23,8 хувийг тус тус хангаад байна. | 2024.04.01<br>2024.10.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Агро-ойн аж ахуй байгуулах, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэхэд газар, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх (Тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөөг хавсаргав. Хамтран ажиллах 2024 оны гэрээний 1 дүгээр хавсралт) | Агро-ойн аж ахуйн тоо, жимс, жимсгэний тариалалт нэмэгдсэн хувь, дэмжлэг үзүүлсэн тоо | Жимс жимсгэнэ 3 га 6,8 тн ургац | Агро ойн аж ахуй байгуулах, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна | Шинээр байгуулагдсан хүлэмжинй цогцолборт ойн зурвас байгуулах ажлыг эхлүүлж, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дэмжлэгтэйгээр 400 ширхэг хайлаас тариалсан. Мөн сумын байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах зардлаас 11 сая төгрөгийн санхүүжилтээр 0,5 га талбайд Өрөл, Агч, Долоогоно, Монос зэрэг 4 нэр төрлийн 200 ширхэг жимсний мод бутыг намрын тарилтаар тарьж хүлээн авсан. | 2024.01.15<br>2024.10.15 | 90 |
| 3. | Хүлэмжийн цогцолборын тариалалтын талбайг нэмэгдүүлж, үерийн шуудуу болон хамгаалалтын тор татаж үйл ажиллагааг жигдрүүлэх | Тариалалт хийсэн өрхийн тоогоор | 120м$^2$ хэмжээтэйг 32 иргэн, 60м$^2$ хэмжээтэй хүлэмжийн газрыг 5 иргэн тус тус хэмжүүлж, тариалалтын ажлаа эхлүүлсэн. | 1200 м$^2$-аас доошгүй талбайд тариалалт хийсэн байна. | 2024 оны 04 дүгээр сард Хүлэмжийн цогцолбор аж ахуйд газар авахаар хүсэлт өгсөн иргэдэд технологийн цогц сургалтыг Бизнесийн шинэ санаа ТББ-тай хамтран зохион байгуулсан. 2024 онд тус цогцолборт 600 метр квадрат талбайд тариалалт хийгдэж, сумын засаг даргын нөөц хөрөнгөөс үерийн хамгаалалтын шуудуу-700 м, 944 м туулай хамгаалалтын тор татах ажилд 4,4 сая төгрөг зарцуулсан. | 2024.04.15<br>2024.10.10 | 100 |
| 4. | Өвөлжөө, хаваржааны 0,7 га газрын дэргэд 1000м$^2$ газарт малын тэжээлийн ургамал тариалах ажлыг эрчимжүүлэх | Малын тэжээлийн ургамал тариалсан өрхийн тоогоор | 16 малчин өрх өвөлжөө хаваржаан дээрээ ногоон тэжээл тариалж, 105 тн ногоон тэжээл хураан | Талбайн болон танхимын сургалт зохион байгуулж, үрийн дэмжлэгт хамруулсан байна. | Аймгийн ХХААГазраас малчин өрхүүдэд өвөлжөө хаваржаан дээрээ ногоон тэжээл тариалахад дэмжлэг болох зорилгоор хөнгөлттэй үнээр овьёосны үр нийлүүлэхээр шийдвэрлэсний дагуу Арвайхээр сумаас 38 өрх тус дэмжлэгт хамрагдаж нийт 26,6 га талбайд ногоон тэжээл тариалж 172 тн ургац хураан авсан байна. | 2023.07.15<br>2023.10.15 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | авсан. | | | | |
| 5. | Тариалангийн талбайн ойн зурвасыг нэмэгдүүлэх, шинээр байгуулах | Ойн зурвас байгуулсан талбайн хэмжээ га | 1,15 га ойн зурвас | Арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, нутагшсан тарьц суулгацаар ханган ажилласан байна. | Сумын байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах зардлаас 11 сая төгрөгийн санхүүжилтээр 0,5 га талбайд Өрөл, Агч, Долоогоно, Монос зэрэг 4 нэр төрлийн 200 ширхэг жимсний мод бутыг намрын тарилтаар тарьж хүлээн авсан. | 2024.05.15 2024.06.15 | 70 |
| 6. | Сумын аюулгүй нөөц бүрдүүлэлт, малчдын хадлан тэжээл бэлтгэл, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах, цаг хүндэрсэн үед хөнгөлөлтэй үнээр өвс, тэжээл нийлүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах | Засгийн газрын тогтоол хувиар, малчдад хөнгөлөлттэй үнээр өвс, тэжээл нийлүүлсэн хэмжээ | Аюулгүй нөөцөд 66 тн өвс, 20 тн тэжээл, малчдын түвшинд өвс 1363 тн, гар тэжээл 454 тн, хужир шүү 810 тн | Аюулгүй нөөцийг бүрдүүлэх тендер зарлаж, нөөцийг бүрдүүлсэн байна. | Малын хөлийн албан татварын хөрөнгөөр 70 сая төгрөгийн санхжүүжилтээр 3 багц бүхий тендер зарлаж, сумын өвс тэжээлийн аюулгүй нөөцөд 37,5 тн өвс, 12,5 тн тэжээлийг татаж, бэлтгээд байна. Арвайхээр сумын бэлчээрийн хөнөөлт мэрэгч ихээр тархсан талбайд микробиологийн аргаар тэмцэхээр сумын малын хөлийн албан татварын хөрөнгөөр 1,53 тн, аймгийн ХХААГ-аас 2 тн нийт 3,53 тн бактержуулсан будааг Ягаан толгойн гүүр, Хөдөө булан цагаан дэрс, Олон дов, Дайргын гол тариалангийн талбай зэрэг 1336 га талбайд цацсан. | 2024.01.15 2024.10.15 | 90 |
| 7. | Тариаланчдын зөвлөгөөн зохион байгуулах, туршлага судлах, сургалт мэдээллээр хангах | Арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тариаланчдын хамрагдсан тоо, борлуулалтын дүн | Аймаг сумын тариаланчдын зөвлөгөөн, үзэсгэлэн худалдаанд 78 тариаланч хамруулсан. | 5-аас доошгүй сургалт, зөвлөгөөнд хамруулж, Арвайхээр сумын тариаланчдын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулсан | 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр Арвайхээр сумын хэмжээнд газар тариалан эрхлэгч иргэдийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Зөвлөгөөнд нийт 28 тариланч хамрагдаж, газар тариалангийн чиглэлээр төрөөс баримталж буй бодлого чиглэл, “Цахим шилжилтийг эрчимжүүлэх” жилийн хүрээнд газар тариалангийн нэгдсэн үйлдвэрлэлийн систем | 2024.05.20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | болох PLANT.MOFA.GOV.MN-ны талаар сургалт, мэдээлэл өгсөн. Мөн хаврын тариалалтын үед тариаланчдад тулгамдаж буй асуудлын талаар санал солилцож, тариаланчдын зөвлөлийн даргаар “Арвин шунхлай” хоршооны дарга Ц.Нямдаш сонгогдсон. | | |
| 8. | Сумын хэмжээнд газар тариалангийн талбайн нэгдсэн тооллого явуулж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хөрсний шинжилгээнд хамруулах | Тариалангийн талбайн тооллогонд хамрагдсан хувь | Шинээр 86 иргэн, аж ахуй нэгж хамрагдаж гэрчилгээжүүлэх ажил хийгдсэн. | Дайргын голын тариалангийн талбайд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэд тооллогод бүрэн хамрагдсан байна. | Арвайхээр сумын газрын даамалтай хамтран шинээр газар авсан болон газрыг зөрчил маргаантай 2 аж ахуй нэгж 3 иргэний гомдлыг газар дээр нь очиж, хэмжилт хийн холбогдох байгууллагад уламжилсан. | 2024.08.01-2024.09.01 | 50 |
| ХОЁР.“ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, ДЭВШИЛТЭД ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛД НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн (plant.mofa.gov.mn) хяналтын системд бүртгэж, үрийн дэмжлэг, мөнгөн болон техникийн урамшуулал авах тариаланчдын тоог нэмэгдүүлэх | Цахим бүртгэл, хөнгөлөлттэй зээл, урамшуулал, төсөл хөтөлбөр, үрийн дэмжлэгт хамруулсан өрх, аж ахуй нэгжийн тоогоор | 10 аж ахуй нэгж, 153 иргэнийг бүртгэлжүүлж, 4 аж ахуй нэгж, иргэний гарал үүслийг баталгаажуулж, урамшууллын хүсэлтийг илгээсэн. | 150-аас тариаланч өрхүүдийн тариалалт, ургалтын явцын арчилгаа хийсэн талаарх мэдээллийг оруулсан байна. | Арвайхээр сумын тариалан эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдэд газар тариалан үйлдвэрлэлийн шинэчлэгдсэн систем болох plant.mofa.gov.mn системийн талаар 2 удаагийн сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 112 иргэн, 15 аж ахуй нэгж хамрагдсан. Тус системд бүртгэлээ баталгаажуулсан 202 иргэн, аж ахуй нэгж хаврын тариалалт, ургалтын явц, ургац хураалт , борлуулалтын талаарх мэдээллээ тогтмол оруулж хэвшээд байна. | 2024.01.15 2024.06.10 | 70 |
| 2. | Газар тариалангийн үйлдвэрлэлтэй холбогдолтой мэдээ, | Тариалалтын мэдээ | Тогтоосон хугацаанд шивж | Тариаланчдаас мэдээг авч нэгтгэн 7 | Тариалалт, ургац хураалтын мэдээг 7 хоногт 2 удаа ХХААГ-т өгч, тариаланч нэг бүрээр төмс, хүнсний | 2024.04.01 2024.11.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээлэл, судалгааг боловсруулах, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээ мэдээллийг холбогдох байгууллага, нэгж албан тушаалтанд хүргүүлэх | | оруулсан. | хоногт 2 удаа | ногоо, хамгаалагдсан хөрс, тариалалт, ургац хураалтын мэдээг эцэслэн гаргаж ХАА-6, ХАА-7, ХАА-8, ХАА-9, ХАА-10 мэдээг статистиктийн нэгдсэн программ medee.app,nso.mn-д хуваарьт хугацаанд нь шивж оруулсан. | | |
| ГУРАВ."ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДЛӨГ БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 1. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, иргэдээс төрин байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэх гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Ирсэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | - | 100 | Арвайхээр сумын хойд хэсгийн тариаланчдын усалгааны шуудуу зуны үерт автаж гурван хэсэгт задарсан, мөн гол шуудуу ус явахгүй бөглөрч битүүрсэн гэсэн тариаланчдын санал хүсэлт, өргөдлийн дагуу Иргэн О.Бямбадоржтой гэрээ байгуулж, 1000 у/м шуудууг шинэчлэн татаж, үерийн төмөр даланг шороогоор хучих, үерийн урсацыг тариалангийн талбайгаас өөр чиглэлд урсгах ажлыг мөн хийж гүйцэтгэсэн. | 2024.05.05<br>2024.11.25 | 100 |
| | | Архивыг хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу бүрдүүлж өгсөн архивын нэгжийн тоо | - | - | | | |
| | | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан эсэх | - | Зөрчилгүй ажилласан байна. | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж зөрчил гаргалгүй ажилласан. | 2024.01.05<br>2024.06.10 | 100 |
| 2. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн болон албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах, биелэлтийг | Үйл ажиллагааны үр дүнгээр | 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 92 хувь үнэлэгдсэн. | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан хагас жилээр тайлагнаж ажилласан | Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө тайлант хугацаанд цахим системд байрлуулсан. | 2024.01.05<br>2024.01.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хагас, бүтэн жилээр тайлагнах, хурал болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах | | | байна | | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Худалдан авах ажиллагаа зохион байгуулах үнэлгээний хороонд ажиллах | Холбогдох хууль тогтоомжийн дагуу санал гомдолгүй ажилласан эсэх | 2023 онд 17 үнэлгээний хороонд ажилласан. | Сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 17 ажил | Сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 10 ажил, харьяа төсөвт сургууль цэцэрлэгийн 13 ажилд үнэлгээний хорооны гишүүн, нарийн бичгээр ажиллаж, цахим болон цаасан холбогдох бичиг баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил , үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу бэлтгэж, гомдол санал зөрчилгүй ажилласан. | 2024.01.05 2024.11.25 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | “Амжилт бол Сонголт” эмэгтэйчүүдийн манлайлалын хөтөлбөрт оролцох | Хувь хүний хөгжлийн чадвар сайжирсан байна. | - | Хувь хүний харилцааны болон бусдад нөлөөлөх, манлайлах ур чадвар сайжирсан байна. | Удирдлагын академиас зохион байгуулсан “Амжилт бол сонголт” эмэгтэйчүүдийн хөтөлбөрт эссэ бичиж, шилдэг оролцогчоор шалгарч, УБ хотод 3 хоногийн хугацаанд сургалтад хамрагдсан. Байгууллагын албан хаагчдын нийгмийн идэвх оролцоог сайжруулж, илтгэх чадварыг | 2024.01.05 2024.06.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэмэгдүүлэн хамт олны дунд эерэг уур амьсгал, хандлагыг бий болгох зорилгоор “Байгууллагын соёл” сэдвээр илтгэлийн уралдааныг зарлаад байна. | | |
| 2. | Монгол бичгийн дунд шатны танхимын болон цахим сургалтад хамрагдах | Унших болох бичгийн чадвар сайжирсан үзүүлэлтээр | Монгол бичгийн анхан шатны мэдлэгтэй. | Монгол бичгийн унших болон бичих ур чадвар сайжирсан байна. | Байгууллагаас зохион байгуулсан монгол бичгийн дунд шатны сургалтад танхимаар хамрагдсан. | 2024.03.05 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Бичиг хэрэг хариуцсан ажилтан / мэргэжилтэн ... Д. Зоибаяр / Д. Зоиг ... / 2024 11 25

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

164